



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 1106

Арвайхээр

Зардал хуваарилж, эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/02 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.2.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аймгийн 2022 оны төсөв батлах” 07/08 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Аймгийн 2022 оны төсөв батлах” 07/08 дугаар тогтоолын 3.3 дахь заалтад тусгагдсан “Суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалын автомашины засвар, шинэчлэл” хийх төсөл арга хэмжээний зардал 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгийг хавсралтад зааснаар зарцуулсугай.

2.Хавсралтын 1, 2 дугаарт тусгагдсан Баянгол, Богд сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд автомашин худалдаж авах зардалд тус бүр 40,000,000 (дөчин сая) төгрөг, 3 дугаарт тусгагдсан Хужирт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд автомашин худалдаж авах зардалд 50,000,000 (тавин сая) төгрөг, 4 дүгээрт тусгагдсан Хархорин сумын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах зардалд 50,000,000 (тавин сая) төгрөг, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах зардалд 70,000,000 (далан сая) төгрөг, нийт 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгийг зарцуулах эрхийг холбогдох сумдын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

3.Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, үр дүн, хэрэгжилтийг тайлагнахыг холбогдох сумын Засаг дарга нарт даалгасугай.

4.Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.




А.ИШДОРЖ

6222 11 0017

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2022 оны...⁰¹
дугаар сарын ...13...-ны өдрийн...^{А.06}
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян төг/
1	Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд автомашин худалдан авах зардал	40,000,0
2	Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд автомашин худалдан авах зардал	40,000,0
3	Хужирт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд автомашин худалдан авах зардал	50,000,0
4	Хархорин сумын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах зардал	50,000,0
5	Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах зардал	70,000,0
	НИЙТ ДҮН	250,000,0

-oOo-